



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885

Цахим хаяг:

gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Сэржмядаг
Утас: 261740

Цахим хаяг:

serjmyadag@audit.gov.mn

Монгол Улсын

Үндэсний аудитын газар:

Засгийн газрын IY байр

Улаанбаатар-15160

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг

Вэб хуудас: www.audit.mn

“Iγayγeyē-Áóaeò” ÕÕĚ

БГД, 18-р хороо,

Sky apartment, 4 давхар, 19 тоот

᠘ᠠᠲᠤᠨᠠᠭ: ᠠ.ᠣᠶᠠᠭᠠᠶᠢᠳᠡ

ᠣᠳᠠᠨ: 70159511

Вэб хуудас:

medeeleaudit@gmail.com

Аудитын тайлан

АГУУЛГА

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	4
2.6	Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал	8
3.1	Түрээсийн сайжруулалтын бүртгэлийн талаар	9
3.2	Ерoint жолоочийн зөрчлийн оноо тооцох төхөөрөмжийн талаар.....	10
3.3	Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг програм болон өгөгдлийн сангийн талаар11	
3.4	Төлөгдөх нь тодорхойгүй авлагын талаар.....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.5	Зорилтот түвшний биелэлт	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ П.ДЭЛГЭРНАРАН
ТАНАА

2018.03.14 № 06/665
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2018\0315SAG88.Docx

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
071233
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнаран танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/296/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай



нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” компанийн ахлах аудитор Д.Товуудорж удирдсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дүгээр сарын 09-ний өдрийн 1/300 дугаартай албан бичгээр “Мэдээлэл-Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН


“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын удирдлага нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Татварын тухай багц хууль, Аудитын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дугаар тушаал “Маягт заавар батлах тухай”, “Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам”, “Татварын өрийн үлдэгдэлд торгууль, алданги тооцох ногдуулах журам”, “Сангийн сайдын тушаал журам батлах тухай” 2010 оны 121 дүгээр тушаал “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам” зэрэг хууль эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна. “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулж, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгуулагдсан бөгөөд дараах зорилго зорилтыг тавьж ажилладаг.

Эрхэм зорилго нь: Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг боловсронгуй болгох, техникийн хяналтын үзлэгийн чанарыг сайжруулж, техникийн найдвартай ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэн, зам, тээврийн осол зөрчилгүй ажиллаж, тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд оршино.

Зорилт: Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангахад оршино.

Тус төв нь Улаанбаатар хотод 1 төв салбар, дүүргүүдэд 5 салбар, орон нутгай 22, улсын хэмжээнд нийт 28 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



Сангийн сайдын 2016 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 228 тоот тушаалаар батлагдсан “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын шинэчилсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 “Үйлдвэрийн газрын өмчлөгч нь төр байх бөгөөд төрийн өмчийн төлөөллийг засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Сангийн яам хэрэгжүүлнэ”, 6 дугаар зүйлийн 6.7 “Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрийн газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж тус тус заасан байна.

“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.


Аудитаар “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оноос мөрдөж байгаа санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС, ашиглаж буй санхүүгийн програмтайгаа нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулахдаа “Ординат” ХХК-ийн бэлтгэсэн UNICUS онлайн програмыг ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.



2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын дотоод хяналтын алба нь “Хяналт шинжилгээ, үнэлгээ, Дотоод аудитын алба” гэсэн нэртэйгээр, 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2016 оны тайлант жилд 2015 оны А/185 тоот үйлдвэрийн газрын захирлын тушаалаар батлагдсан “Хяналт шинжилгээ, үнэлгээний журам”-ын дагуу дотоод нэгж хэлтсүүдэд үнэлгээ хийх ажлыг голлон хийсэн байна. Дотоод хяналтын ажилтнуудыг сонгохдоо ажлын байрны шаардлагад нийцүүлээгүй байгааг удирдлагад зөвлөж, танилцуулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон тус байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба хамтран 2017 оны 05 дугаар сарын 21-нээс 30 хоногийн хугацаатай Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2016, 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтэнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.

ЗТХЯ-тай хамтарсан шалгалтаар санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 13 төрлийн зөвлөмж өгч, биелэлтийн тайланг 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр дүгнэн ажиллажээ.

2.6 Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу төлөвлөгөөний санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төлөвлөгөөг зардлын төрөл, зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.


Зорилтот түвшингийн тодотгосон төлөвлөгөөгөөр 18,878.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 22,759.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж 120 хувиар биелүүлсэн.

Нийт зардлыг 16,874.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 96 хувиар буюу 16,259.1 сая төгрөгийг зарцуулж, татварын өмнөх ашгийг төлөвлөгөөнөөс 324 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн болон улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2017 оны зорилтот түвшин, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн зорилтот түвшин, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого,



зарлагын мөнгөн гүйлгээг цахим санд 18 төрлийн мэдээллийг сар, улирал, жилийн давтамжтай, 144 мэдээлэл байршуулсан байна. Холбоос:

<https://www.shilendans.gov.mn/org/5158?group=2&year=2017>

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Хүүгийн орлогын талаар

Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд байршуулсан тусгай гэрээт хадгаламжийн 15,4 сая төгрөгийн хүүгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "аж ахуй нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөнө" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Хүүгийн орлого 15.4 сая төгрөгийг орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнаж залруулсан.

Татварын зардлын талаар

Хөдөлмөр хамгааллын зардлаас зарцуулсан ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсан 21.0 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйл "Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал" 12.1.23-д "Хөдөлмөр хамгааллын зардал" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Хөдөлмөр хамгааллын зардал 21.0 сая төгрөгийг үйл ажиллагааны зардлаар бүртгэж залруулсан.


Түрээсийн сайжруулалтын бүртгэлийн талаар

"ХӨСӨГ" ХК-тай 2006 онд 01/04 тоот гэрээ байгуулж 288 м2 талбайг 5 жилийн хугацаатай түрээслэсэн. Түрээсийн байранд 102.1 сая төгрөгийн засвар хийхээр гэрээнд тусгаж, хийгдсэн засварын зардлыг жилд 2.5 хувиар буюу 40 жилийн хугацаанд элэгдэл байгуулахаар тусгасан нь НББОУС-ын 17 дугаар зүйлийн 52-т "Үйл ажиллагааны түрээс хийх, тохиролцохтой холбоотойгоор түрээслүүлэгчээс гарсан анхдагч шууд зардлыг түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, түрээсийн орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй ижил сууриар түрээсийн хугацааны турш зардлаар хүлээн зөвшөөрөх" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Түрээсийн сайжруулалтын зардлыг түрээсийн гэрээнд заасан хугацаанд хувиарлан зардалд шингээх.

Ерoint жолоочийн зөрчлийн оноо тооцох төхөөрөмжийн талаар

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа нийт 58.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Ерoint жолоочийн зөрчлийн оноо тооцох програм, програмын Сервер /Dell R820 intel xoen E5-4650/



Хадгалах төхөөрөмж-/Dell PS4210XV/-үүд Замын цагдаагын газар ашиглагдаж байгаа нь НББОУС-ын 16 дугаар зүйлийн 7а-д "хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай" үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэсэн заалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгсөн

Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг програм болон өгөгдлийн сангийн талаар

Монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг програм болон өгөгдлийн сангийн серверийг ашиглаж байгаа бөгөөд энэ нь төвийн хөрөнгийн бүртгэлд бүртгэлгүй байгаа нь НББОУС-ын 16 дугаар зүйлийн 7а-д "хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай" үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж заасныг зөрчсөн. Энэхүү програм, серверээс мэдээлэл алдагдах, бүртгэлгүй хууль бус хандалт хийх өндөр эрсдэлтэй тул бүртгэлжүүлж, хяналт тавих шаардлагатай.

Шийдвэрлэсэн: Энэхүү програм, серверээс мэдээлэл алдагдах, бүртгэлгүй хууль бус хандалт хийх өндөр эрсдэлтэй тул бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллах зөвлөмж өгсөн

Төлөгдөх нь тодорхойгүй авлагын талаар

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т "Тээвэр авто замын газар"-ыг нэгтгэхэд балансаас балансад шилжиж ирсэн, 4 аймгийн төрийн сан, харилцагч байгууллагуудтай холбоотой эзэн холбогдогч нь тодорхойгүй 17.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэснийг мөрдөөгүй

Шийдвэрлэсэн: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч, ТӨБЗГ-т асуудлыг хүргүүлэн шийдвэрлүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй, эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахаар тогтов.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 114.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 36.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 78 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.



2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Мэдээлэл-Аудит” ХХК 2 зөвлөмж өгсөнийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үед зардлын гүйцэтгэл 16,259.2 сая төгрөгийн 1 хувь 162.6 сая төгрөгөөр авсан бөгөөд гүйцэтгэлийн үед материаллагыг өөрчлөөгүй болно.

Аудитын багийн гишүүд зөвшилцөн, байгууллагын онцлог, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан үзэж 1 хувийг сонгосон.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь төрийн тодорхой чиг үүргийг дангаараа хэрэгжүүлдэг, орлого бүрдүүлэлт монополь шинж чанартай бөгөөд техникийн үзлэг оношлогооны үнэ тариф өссөнөөс шалтгаалан төлөвлөсөн орлогын биелэлт 60 хувиар өссөн байна.

Гэтэл санхүүгийн тайлант жилд бүтцийн болон орон тооны өөрчлөлт байхгүй атал нийт зардал 20 хувиар өссөн байгаа нь үнэ тарифын өсөлттэй хамаарал бага тул зардлыг суурь болгон сонгосон болно. Тус байгууллагын Төлөвлөлтийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“Мэдээлэл-Аудит”ХХК нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 ТҮРЭЭСИЙН САЙЖРУУЛАЛТЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

"ХӨСӨГ" ХК-тай 2006 онд 01/04 тоот гэрээ байгуулж 288 м2 талбайг 5 жилийн хугацаатай түрээслэсэн. Түрээсийн байранд 102.1 сая төгрөгийн засвар хийхээр гэрээнд тусгаж, хийгдсэн засварын зардлыг жилд 2.5 хувиар буюу 40 жилийн хугацаанд элэгдэл байгуулахаар тусгасан нь НББОУС-ын 17 дугаар зүйлийн 52-т "Үйл ажиллагааны түрээс хийх, тохиролцохтой холбоотойгоор түрээслүүлэгчээс гарсан анхдагч шууд зардлыг түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, түрээсийн орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй ижил сууриар түрээсийн хугацааны турш зардлаар хүлээн зөвшөөрөх" гэж заасныг зөрчсөн.

Аудитын зөвлөмж

НББОУС-17-г мөрдөж, түрээсийн сайжруулалтын зардлыг түрээсийн гэрээнд заасан хугацаанд хувиарлан зардалд шингээх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл, үнэн зөв байдал, үнэлгээ батламж мэдэгдлүүд зөрчигдөх

НББОУС-17 зөрчигдөх

Байгууллагын хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Ероинт жолоочийн зөрчлийн оноо тооцох төхөөрөмжийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа нийт 58.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Ероинт жолоочийн зөрчлийн оноо тооцох програм, програмын Сервер /Dell R820 intel хоеп Е5-4650/, Хадгалах төхөөрөмж-/Dell PS4210XV/-үүд Замын цагдаагын газар ашиглагдаж байгаа нь НББОУС-16-ын 7а-д "хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай" үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэсэн заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын зөвлөмж

ТӨБЗГ-т асуудал хүргүүлэн шийдвэрлүүлж, тус хөрөнгө байрлаж буй Замын цагдаагын газарт шилжүүлэн бүртгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

НББОУС-17 Үндсэн хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэх стандартыг зөрчих

НББ-д бүртгэгдсэн хөрөнгөнд тавих хяналт сулаас шамшигдах эрсдэл үүсэх

Оршин байгаа, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг програм болон өгөгдлийн сангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

Монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг програм болон өгөгдлийн сангийн серверийг ашиглаж байгаа бөгөөд энэ нь төвийн хөрөнгийн бүртгэлд бүртгэлгүй байна. НББОУС-16-ын 7а-д "хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай" үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж заасныг зөрчсөн.

Аудитын зөвлөмж

Энэхүү програм, серверээс мэдээлэл алдагдах, бүртгэлгүй хууль бус хандалт хийх өндөр эрсдэлтэй тул бүртгэлжүүлж, хяналт тавих.


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Оршин байгаа, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх
Үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй хөрөнгө бүртгэлгүй байх нь хяналтгүй болох эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажиглалд танилцуулсан болно.



3.4 Төлөгдөх нь тодорхойгүй авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

2008 онд үүссэн "Тээвэр авто замын газар"-ыг татан буулгаж, АТҮТ ТӨҮГ-т нэгтгэхэд балансаас балансад шилжиж ирсэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй 17.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь НББ тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэснийг мөрдөөгүй.

Аудитын зөвлөмж

Авлагыг барагдуулах арга хэмжээ авч, ТӨБЗГ-т асуудлыг хүргүүлэн шийдвэрлүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;


Эрсдэлүүд

Оршин байгаа, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн аудитын бүтэц, санхүүгийн ажлын тайлангаар илэрхийлсэн болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Байгууллагын тайлан		Залруулсан дүн	Аудит хийгдсэн тайлан
		1 сарын 1	12 сарын 31		
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00		0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00		0
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,518,391,170.57	1,743,325,354.28		1,743,325,354.28
1.1.02	Дансны авлага	5,205,955.00	3,735,153.00		3,735,153.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	23,987,175.94		23,987,175.94
1.1.04	Бусад авлага	55,879,882.23	80,823,261.04	15,391,904.45	96,215,165.49
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00		0.00
1.1.06	Бараа материал	1,328,689,713.61	1,486,664,027.68		1,486,664,027.69
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	673,522,104.27	2,349,767,004.87		2,349,767,004.87
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	14,585,000.00	18,628,000.00		18,628,000.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө				
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,596,273,825.68	5,706,929,976.81	15,391,904.45	5,722,321,881.27
1.2	Эргэлтийн бус хөрөнгө				
1.2.01	Үндсэн хөрөнгө	15,023,505,904.29	16,572,260,276.57		16,572,260,276.57
1.2.02	Биет бус хөрөнгө	234,707,279.33	292,712,357.72		292,712,357.72
1.2.03	Биологийн хөрөнгө				
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт				
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө				
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө		5,748,714.54		5,748,714.54
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө				
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө				
1.2.09	Дуусаагүй барилга				
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15,258,213,183.62	16,870,721,348.83	0.00	16,870,721,348.83
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,854,487,009.30	22,577,651,325.64	15,391,904.45	22,593,043,230.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
2.1	Өр төлбөр				
2.1.1	Богино хугацаат өр төлбөр				
2.1.1.01	Дансны өглөг	154,554,739.37	198,349,787.97		198,349,787.97
2.1.1.02	Цалингийн өглөг	6,131,349.53	150,123.00		150,123.00
2.1.1.03	Татварын өр	221,106,737.89	49,712,201.76	633,480.46	49,078,721.30
2.1.1.04	НДШ - ийн өглөг	6,850,416.08	943,200.00		943,200.00
2.1.1.05	Богино хугацаат зээл				
2.1.1.06	Хүүний өглөг				
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг		324,651,420.00		324,651,420.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	49,705,533.45	106,139,986.18		106,139,986.18
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/				
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр				
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр				
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	438,348,776.32	679,946,718.91	633,480.46	679,316,238.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр				
2.1.2.01	Урт хугацаат зээл	7,825,841,746.28	6,606,464,648.25		6,606,464,648.25

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ

САНАЛ ДЭГНЭЭТ

2.1.2.02	Нөөц /өр төлбөр/				
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр				
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр				
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,825,841,746.28	6,606,464,648.25		6,606,464,648.25
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,264,190,522.60	7,286,411,367.16	633,480.46	7,285,777,886.70
2.3	Эздийн өмч				
2.3.01	Өмч: - төрийн	241,840,000.00	241,840,000.00		241,840,000.00
2.3.02	- хувийн				
2.3.03	- хувьцаат				
2.3.04	Төв компаний тооцоо				
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал				
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	134,585,950.05	133,416,650.05		133,416,650.05
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	11,959,488,314.20	12,399,299,419.99		12,399,299,419.99
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,745,617,777.55	2,516,683,888.44	16,025,384.91	2,532,709,273.35
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-1,032,050,339.36	5,219,466,490.48	16,025,384.91	5,235,491,875.39
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-713,567,438.19	-2,702,782,602.04		-2,702,782,602.04
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,590,296,486.70	15,291,239,958.48	16,025,384.91	15,307,265,343.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,854,487,009.30	22,577,651,325.64	0.00	22,593,043,230.09



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Байгууллагын тайлан		Залруулсан дүн	Аудит хийгдсэн тайлан
		Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн		
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,811,391,284.86	17,668,317,290.59		17,668,317,290.59
2	Борлуулалтын өртөг	11,826,837,972.46	14,141,472,992.70	21,726,709.09	14,163,199,701.79
3	Нийт ашиг(алдагдал)	-2,015,446,687.60	3,526,844,297.89	(21,726,709.09)	3,505,117,588.80
4	Түрээсийн орлого	95,017,621.23	103,227,680.01		103,227,680.01
5	Хүүний орлого	98,136,171.71	251,862,211.59	15,391,904.45	267,254,116.04
6	Борлуулалтын орлого-мал амьтад	4,012,727.27	4,989,272.73		4,989,272.73
7	Зорчигч тээврийн орлого	3,973,238,385.66	4,715,282,329.03		4,715,282,329.03
8	Бусад орлого		0.00		0.00
8.1	Орлогын дүн	4,170,404,905.87	5,075,361,493.36	15,391,904.45	5,090,753,397.81
9	Борлуулалт, маркетингийн зардал	135,939,512.54	279,387,933.39		279,387,933.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,130,696,804.75	1,290,953,653.21		1,290,953,653.21
11	Санхүүгийн зардал	-			
12	Бусад зардал	-			
12.1	Зардлын дүн	1,266,636,317.29	1,570,341,586.60		1,570,341,586.60
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-1,320,038,232.97	-234,660,661.84		-234,660,661.84
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	500,000.00			
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-			
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-			
17	Бусад ашиг (алдагдал)	-511,901,817.33	-312,765,314.28	21,726,709.09	-291,038,605.19
17.1	Олз, гарзын дүн	-1,831,440,050.30	-547,425,976.12	21,726,709.09	-525,699,267.03
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-943,118,149.32	6,484,438,228.53	15,391,904.45	6,499,830,132.98
19	Орлогын татварын зардал	88,932,190.04	1,264,971,738.05	(633,480.46)	1,264,338,257.59
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,032,050,339.36	5,219,466,490.48	16,025,384.91	5,235,491,875.39
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-			
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,032,050,339.36	5,219,466,490.48	16,025,384.91	5,235,491,875.39
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-			
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-		
23.3	Бусад олз (гарз)	-	-		
24	Орлогын нийт дүн	-	-		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2015 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,340,902,952			135,633,600		3,504,103,116	-713,567,438	11,267,072,230
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								0
03	Залруулсан үлдэгдэл								0
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-1,032,050,339	-1,032,050,339
05	Бусад дэлгэрэнгүй орлого								0
06	Өмчид гарсан өөрчлөлт	8,099,062,952					8,455,385,198		356,322,247
07	Зарласан ногдол ашиг								0
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-1,047,650				-1,047,650
09	2016 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	241,840,000			134,585,950		11,959,488,314	-1,745,617,778	10,590,296,487
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-596,441,024	-596,441,024
11	Залруулсан үлдэгдэл							-2,342,058,802	9,993,855,462
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							5,235,491,875	5,235,491,875
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт						439,811,106		439,811,106
15	Зарласан ногдол ашиг							-360,723,800	-360,723,800
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-1,169,300				-1,169,300
17	2017 оны 12 сарын 31-р үлдэгдэл	241,840,000			133,416,650		12,399,299,420	-2,532,709,278	15,807,265,343




4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	33,935,223,057.51	53,952,247,272.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,812,780,321.76	23,836,192,841.89
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,931,135.00	30,790,554.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	19,113,511,600.75	30,085,263,876.67
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,392,055,273.64	50,346,776,859.44
1.2.1	Ажиллагчдад төлсөн	8,353,303,910.62	9,271,466,594.63
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,143,097,237.53	1,627,247,754.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	396,402,756.97	598,715,737.81
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	678,421,800.99	780,081,519.95
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	227,933,622.58	538,030,441.06
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		460,318,390.17
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	892,638,616.53	3,098,550,151.49
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	51,439,440.00	57,968,723.36
1.2.9	Бусад мөнгөн зарлага	21,648,817,888.42	33,914,397,546.30
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	543,167,783.87	3,605,470,413.12
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	98,136,171.71	253,517,211.59
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	1,655,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	98,136,171.71	251,862,211.59
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	849,055,414.00	3,634,524,681.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	701,370,976.00	2,064,979,042.35
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	147,684,438.00	115,533,880.00
	Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		1,454,011,758.65
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-750,919,242.29	-3,381,007,469.41
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		471,240.00
3.1.3	Төрөл бүрийн хандив		471,240.00
3.1.4	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		471,240.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-207,751,458.42	224,934,183.71
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,726,142,628.99	1,518,391,170.57
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,518,391,170.57	1,726,142,628.99



4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016 оны гүйцэтгэл	2017 оны батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
						Хувиар	Төгрөгөөр
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
Үүнээс	Үүнээс: Техникийн хяналт оношлогоо	тоо хэмжээ	5,514,822.6	10,921,850.0	11,633,810.9	107%	711,960.9
	Зорчигч тээвэр.	зорчигч болон ачаа эргэлт	7,181,633.6	6,347,200.0	9,374,318.6	148%	3,027,118.6
	Бүртгэл, Бусад	мян /төг	1,285,340.4	1,609,556.0	1,750,941.1	109%	141,385.1
2	Нийт орлого	мян /төг	13,981,796.6	18,878,606.0	22,759,070.6	121%	3,880,464.6
3	Нийт зардал	мян /төг	13,605,376.0	16,874,585.0	16,259,240.5	96%	(615,344.5)
4	Татварын өмнөх ашиг	мян /төг	376,420.6	2,004,021.0	6,499,830.1	324%	4,495,809.1
5	Цэвэр ашиг/алдагдал	мян /төг	338,778.5	1,803,618.9	5,235,491.8	290%	3,431,872.9
6	Орлогын татварт	мян /төг	37,642.1	200,402.1	1,264,338.3	631%	1,063,936.2
7	Төсвийн төлбөрт	мян /төг	4,320,989.2	2,215,000.0	3,461,459.6	156%	1,246,459.6
8	Нийт авлага	мян /төг	61,085.7	99,500.0	99,950.3	100%	450.3
9	Нийт өглөг	мян /төг	8,264,190.5	5,890,550.2	6,854,986.5	116%	964,436.3
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян /төг	0.97	0.89	0.71	80%	(0.2)
11	Ногдол ашиг	мян /төг	20,316.9	360,723.8	360,723.8		-
12	Хөрөнгө оруулалт	мян /төг	1,525,575.0	5,091,346.0	4,824,516.4	106%	(266,829.6)

